Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А/05 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн баталсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын прокурорын ерөнхий газар	
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Улсын ерөнхий прокурорын хууль зүйн асуудал хариуцсан туслах прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	Хамаарахгүй

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:
Улсын ерөнхий прокурор эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулахад чиглэсэн шийдвэр гаргах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох ажиллагаанд хууль зүйн дэмжлэг үзүүлэх.

Албан тушаалын зорилт:
1.Улсын ерөнхий прокурорын бүрэн эрхийн хүрээнд гаргах шийдвэр, эрх зүйн баримт бичгийг хуульд нийцүүлэх арга хэмжээ авах, холбогдох хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох асуудлаар санал гаргах;
2.Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах хүрээнд зарим чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Прокурорын байгууллагын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийн төслийг боловсруулах, хянах, Улсын ерөнхий прокурорт санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Санал танилцуулж шийдвэрлүүлсэн байна.	Г, Х
	1.2.Улсын ерөнхий прокуророос эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд хүргүүлэх мэдээллийн төслийг хянаж, Улсын ерөнхий прокурорт санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Төслийг хянаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х
	1.3.Улсын ерөнхий прокуророос Ерөнхийлөгч, Засгийн Газар, Үндсэн Хуулийн Цэц, Улсын Дээд Шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, хүсэлт, дүгнэлтийн төслийг хянаж, танилцуулан шийдвэрлүүлэх.	Төслийг хянаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х
	1.4.Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх үндэслэл, шаардлагыг судлах, санал, төсөл боловсруулан Улсын ерөнхий прокурорт танилцуулж шийдвэрлүүлэх.	Судалж, танилцуулсан байна.	Г, Х
	1.5.Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс хууль, дүрэм, заавар, журмын төсөлд тусгуулахаар боловсруулсан саналын төслийг хянаж, танилцуулан шийдвэрлүүлэх.	Саналын төслийг хянаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х
	1.6.Улсын ерөнхий прокурорын тушаалаар батлагдах заавар, журмын төслийг хянаж, санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Төслийг хянаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х
	1.7.Улсын ерөнхий прокуророос гаргах бусад шийдвэр, үүрэг чиглэлийн төслийг боловсруулж танилцуулах, төслийг хянаж, санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Төслийг хянаж, холбогдох арга хэмжээ авсан байна.	Х

	1.8.Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний явц, үр дүнгийн байдалтай тогтмол танилцан, Улсын ерөнхий прокурорт тухай бүр нь дүгнэлт, санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Арга хэмжээний явц байдалтай танилцаж, санал, дүгнэлт гаргасан байна.	Г, Х
	1.9.Улсын ерөнхий прокуророос өгсөн үүргийг хэрэгжүүлж, хариуцсан чиг үүрэгтэй холбоотой мэдээллээр хангах.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, мэдээллээр хангасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Улсын ерөнхий прокурорын цохолтын дагуу иргэн, хуулийн этгээд, хэргийн оролцогчоос гаргасан гомдол, хүсэлт, холбогдох хэрэг, материалыг хянаж, санал танилцуулан шийдвэрлүүлэх.	Хэрэг, материалыг хянаж, танилцуулсан байна.	Г, Х
	2.2.Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний танилцуулга, илтгэх хуудастай танилцаж, үүрэг чиглэл өгөх санал танилцуулж, шийдвэрлүүлэх.	Танилцуулга, илтгэх хуудастай танилцаж, санал гаргасан байна.	Г, Х
	2.3.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй (0421)	
Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажилгаагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Дээд шатны прокуророор 3-аас доошгүй жил, эсхүл Улсын ерөнхий прокурорын газарт ахлах прокуророор ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хариуцсан ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох;

		-хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Улсын ерөнхий прокурор

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект
1.Улсын ерөнхий прокурорын туслах ажилтан-ахлах шинжээч Нийт: 1	1.Нэгдүгээр прокурорын газрын прокурор, ажилтан 2.Төрийн байгууллага 3.Иргэн, хуулийн этгээд

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар: А/95

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр